*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*2 дугаар хавсралт*

# ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН БЯМБАДОРЖИЙН НАРАНТУЯАГИЙН 2024ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Стратегийн зорилго 7. Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ.** | | | | | | | |
| **Зорилт 1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах, хяналт тавих хүрээнд** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай" 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээ | Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд хариулгагүйгээр бэлчээсэн нийт давхардсан тоогоор 141 иргэний 3127 малыг хориглосон бүсээс тууж гарган, 10 иргэний 29 тооны үхэр, 60 гаруй тооны адууг хашаалан, 11 иргэнд 1.050 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 01 | 12 |
| 2. | **Арга хэмжээ 1.2** Дүүргийн газар тариалангийн салбарт Кластерын жишиг загварыг бий болгон, хүлэмжийн ногоо тариалах, боловсруулах технологи, стандарт (GAP, HACCP)-г нэвтрүүлж, "Хан-Уулд тариалав" | Зохион байгуулсан ажлын тоо | 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 1 брэнд бүтээгдэхүүнтэй болсон. | 2 арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1 брэнд бүтээгдэхүүнтэй болсон. | 01 | 12 |

495

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | брэнд бий болгох ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 3. | **Арга хэмжээ 1.3**<br>Хүлэмжийн аж ахуй, хүнсний ногоо, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин, жимс, жимсгэний суулгац, үржүүлгийн талаар сургалт зохион байгуулж, хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, дэмжин ажилласан газар тариалан эрхлэгчдийн тоо | 5 арга хэмжээ зохион байгуулж, 173 өрхийн тариалалтыг дэмжсэн. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж, хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлсэн байна. | 1 арга хэмжээ зохион байгуулсан байна. | 03 | 11 |
| 4. | **Арга хэмжээ 1.4.**<br>Дүүргийн нутаг дэвсгэрт хүнсний ногоо тариалж буй иргэн, ААНБ-дад "Ургамал. ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд гарал, үүслийн гэрчилгээ" олгох, хяналт тавих ажлыг зохион байгуулна. | Зөвлөн тусалсан болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ олгосон тариаланчдын тоо. | 18 иргэн, аж ахуйн нэгжийн 599.2 тн хүнсний ногоонд гарал үүслийн гэрчилгээ олгосон. | Цахим бүртгэлийн системийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | 20-иос доошгүй тариаланчдад "Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ" олгосон байна. | 03 | 12 |
| 5. | **Арга хэмжээ 1.5.**<br>Малд үзлэг ангилалт хийх, ялган тэмдэглэл тэмдэглэж бүртгэлжүүлэх, удам зүйн үнэлгээ хийх замаар малын ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлох, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан ажлын тоо | - | - | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 08 | 10 |
| **Зорилт 2. Хүнсний аюулгүй байдлыг хангах, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах хүрээнд** | | | | | | | |
| 6. | **Арга хэмжээ 2.1.**<br>Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулж ажиллана. | Худалдаа зохион байгуулсан байршлын тоо, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ | 5 удаагийн арга хэмжээнд 40.9 гаруй тонн төмс, хүнсний ногоог худалдаж, 120.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. | - | 1.1.1 Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа гаргах байршил батлагдсан байна.<br>1.1.2.Хүнсний ногооны худалдаа 3-4 байршилд гарсан байна.<br>1.1.3 Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ногооны борлуулалт, чанар, | 08 | 11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрүүл ахуйд хяналт тавьж, цахим төлбөрийн баримт, гарал үүсэл олгож ажилласан байна. | | |
| 7 | **Арга хэмжээ 2.2.** Эрсдэл үүссэн үед малчин, мал бүхий иргэдийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах ажлыг зохион байгуулж, дүүргийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна. | Малчин, мал бүхий иргэдэд өвс, тэжээлийн дэмжлэг үзүүлсэн тоо хэмжээ | 40тн-оос багагүй хэмжээний өвс, тэжээлийн дэмжлэг үзүүлсэн байна. | Бэлтгэсэн өвс, тэжээлийг шаардлагатай цэгүүдэд байршуулж, малчдад тараасан байна. | - | 01 | 03 |
| 8 | **Арга хэмжээ 2.3** Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувь | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 9 удаагийн дархлаажуулалтад 340708 мал, амьтан хамрагдаж, 97.2 хувь, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 удаагийн дархлаажуулалтад 105425 бог мал, гүйцэтгэл 98.9 хувь | 90% | 98% | 01 | 12 |
| 9 | **Арга хэмжээ 2.4.** Болзошгүй гамшиг ослын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулсан ажлын тоо | Болзошгүй гамшиг ослын үед хүнс нийлүүлэх гэрээг 30 аж ахуйн нэгжтэй байгуулж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгаа, хүн хүч, агуулах, хүнс тээвэрлэх тээврийн хэрэгслийн судалгааг нарийвчлан гаргаж, бэлэн байдлыг хангуулан ажилласан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1-ээс доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 01 | 12 |
| | **Стратегийн зорилго 6. Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болсон байна.** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд** | | | | | | | |
| 10 | **Арга хэмжээ 3.1.** Цахим болон цаасан баримт бичгийг хүлээн авах, хуулийн хугацаанд шийдвэрлэх, албан хэрэг хөтлөлтийн талаарх бодлого стандарт журмыг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах. | Албан бичгийн тоо, шийдвэрлэлтийн хувь | Дээд газар болон бусад байгууллагаас ирүүлсэн 145 албан бичгийг хүлээн авч 100% шийдвэрлэж, холбогдох хэлтэс албадад 87 албан бичиг боловсруулан хүргүүлсэн. | 100% | 100% | 01 | 12 |
| 11 | **Арга хэмжээ 3.2.** Иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг судлан, хуулийн дагуу шийдвэрлэн хариу өгөх. | Өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Иргэдээс ирсэн 21 өргөдлийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн. | 100% | 100% | 01 | 12 |
| 12 | **Арга хэмжээ 3.4.** Баримт бичгийг албан бичгийн стандартын дагуу зохион бүрдүүлэх, архивын стандартад нийцүүлэн байгууллагын архивт хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгөх. | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээлгэн өгсөн баримтын тоо | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан 3 хадгаламжийн нэгжийг архивын стандартын дагуу үүсгэж, хуваарийн дагуу байгууллагын архивт хүлээлгэн өгсөн. | 2-оос доошгүй хадгаламжийн нэгж үүсгэн, архивчид хүлээлгэн өгсөн байна. | - | 02 | 03 |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо хэмжээ | Дээд шатны болон Тамгын газраас зохион байгуулсан 8 удаагийн сургалт, семинарт хамрагдсан | 4 | 4 | 01 | 12 |
| 2. | Арга хэмжээ 2. Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн хэрэглээний болон | Суралцсан сургалтын тоо | Зохиолч, Ментор Т.Гүлдаурений хувь хүний хөгжлийн хөтөлбөрүүд болох | - | Мэдээллийн технологийн хэрэглээний программын талаар | 06 | 12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмшинэ. | | "Mommy mentor" 15 өдрийн цахим хөтөлбөрт хамрагдсан. | | бие дааж суралцсан байна. | | |

**ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ........................... / Б.НАРАНТУЯА/ 2024.01.08

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА ........................... / Л.САРУУЛТУЯА / 2024.01.08

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХАРИУЦСАН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН БЯМБАДОРЖИЙН НАРАНТУЯАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах, хяналт тавих хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай” 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээ | Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд хариулгагүйгээр бэлчээсэн нийт давхардсан тоогоор 141 иргэний 3127 малыг хориглосон бүсээс тууж гарган, 10 иргэний 29 тооны үхэр, 60 гаруй тооны адуут хашаалан, 11 иргэнд 1.050 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 4 удаагийн нэгдсэн арга хамжээ зохион байгуулж, 19.1сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан. Үүнд:<br>- Дүүргийн хэмжээнд 4 ажилтанг ажиллуулж, ажлын цаг ашиглалт, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.<br>- Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд орж ирсэн 98 иргэний 1827 тооны адуут эздэд нь хүлээлгэн өгч, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу 1 иргэнд 3 сая, Зөрчлийн тухай хуулиар 2 иргэнд 250, 18 иргэнд тус бүр 1 сая, нийт 17.5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг тус тус авсан.<br>- Шинэчлэгдэн батлагдсан тогтоолыг мал бүхий хороодын 450 иргэнд танилцуулах уулзалт, сургалтыг зохион байгуулсан. | 2024.01.02-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Малчин, мал бүхий иргэд малаа байнгын хариулгатай зөвшөөрсөн бүсэд бэлчээхийг анхааруулсан зурагт хуудас, видео шторкийг дүүрэг хорооны цахим хуудсуудад байршуулсан иргэдэд сурталчлан ажилласан.<br>"Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх журам"-ын 2.3-т заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг, удирдамжийг дүүргийн Засаг даргын 2024 оны А/453 дугаар захирамжаар баталж, сонгон шалгаруулалтыг 2 удаа зарласан. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2<br>Дүүргийн газар тариалангийн салбарт Кластерын жишиг загварыг бий болгон, хүлэмжийн ногоо тариалах, боловсруулах технологи, стандарт (GAP, HACCP)-г нэвтрүүлж, "Хан-Уулд тариалав" брэнд бий болгох ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан ажлын тоо | 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 1 брэнд бүтээгдэхүүнтэй болсон. | 2 арга хэмжээ зохион байгуулсан байна. | Дүүргийн газар тариалангийн салбарт кластерын жишиг загварыг бий болгон, хүлэмжийн ногоо тариалах, боловсруулах технологи, стандартыг нэвтрүүлж, "Хан-Уулд тариалав" брэнд бий болгох зорилтын хүрээнд дүүргийн Засаг даргын 2024 оны "Баялаг бүтээгч өрхийг дэмжих тухай" А/233 дугаар захирамжийг баталж, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, баялаг бүтээгч өрхийг дэмжих ажлыг 2 үе шаттай зохион байгуулсан.<br>Хан-Уулд тариалав брэндинг бий болгох ажлын хүрээнд "Оюу фамили" ХХК-ийн зөгийн бал, 3-р хорооны иргэн А.Атарцэцэгийн үйлдвэрлэж буй "Даршилсан сармис","Амаркатеринг" ХХК-ийн 8 төрлийн салат навчийг брэнд бий болгох зорилгоор нийслэл, дүүргээс зохион байгуулсан 3 удаагийн үзэсгэлэн худалдаанд оролцуулж, сурталчлах ажлыг зохион байгуулсан. Мөн Ургамал хамгааллын цогц аргыг хүлэмжид тариалсан өргөст хэмхийг нэвтрүүлэх туршилтын төслийг амжилттай хэрэгжүүлсэн хүлэмжийн тариалан эрхлэгч "Амар | 2024.01.02-2024.11.29 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | кэтеринг" ХХК-нд НҮБ-ын ХХААБ-тай хамтран GAP-ын гэрчилгээг гардуулсан. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3<br>Хүлэмжийн аж ахуй, хүнсний ногоо, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин, жимс, жимсгэний суулгац, үржүүлгийн талаар сургалт зохион байгуулж, хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, дэмжин ажилласан газар тариалан эрхлэгчдийн тоо | 5 арга хэмжээ зохион байгуулж, 173 өрхийн тариалалтыг дэмжсэн. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж, хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлсэн байна. | Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран "Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн мод тариалах технологи" сургалтыг 2 удаа зохион байгуулж, 102 тариалан эрхлэгчийг хамруулсан.<br>Хаврын тариалалтад зориулж 6.3 сая төгрөгийн үнэ бүхий 10 нэр төрлийн 142 уут, 825.5 кг хүнсний ногооны үрийг 13, 14 дүгээр хорооны 366 өрхөд үнэ төлбөргүй олгож тариалалтыг дэмжин ажилласан. Дүүргийн хэмжээнд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж буй 29 аж ахуйн нэгж,151 иргэн 29.1 га талбайд төмс, 146.3 га талбайд хүнсний ногоо тариалж 2496.4тн ургац, 28.2га хүлэмжийн талбайгаас 515.7тн өргөст хэмх, 149тн улаан лооль, 74.8тн чинжүү, 238.7тн навчит ногоо хураан авсан тоон мэдээг нэгтгэн холбогдох газар хэлтсүүдэд хүргүүлсэн. | 2024.01.02-2024.11.20 | 100% |
| 4. | Арга хэмжээ 1.4.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт хүнсний ногоо тариалж буй иргэн, ААНБ-дад "Ургамал. ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд гарал, үүслийн гэрчилгээ" олгох, хяналт тавих ажлыг зохион байгуулна. | Зөвлөн тусалсан болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ олгосон тариаланчдын тоо. | 18 иргэн, аж ахуйн нэгжийн 599.2 тн хүнсний ногоонд гарал үүслийн гэрчилгээ олгосон. | Цахим бүртгэлийн системийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"-ын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:<br>- "Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн plant.mofa.gov.mn цахим систем"-д 344.5га тариалангийн талбай бүхий 215 тариаланчийг тулган баталгаажуулсан.<br>- Гарал үүслийн гэрчилгээ олгох шаардлагатай 24 газар тариалан эрхлэгчийн 25 нэр төрлийн төмс, хүнсний ногооноос дээж авч, ургамлын өвчин хортон, хог ургамал, пестицид, нитратын үлдэгдэл тодорхойлуулахаар итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн 111.8тн хүнсний | 2024.01.02-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ногоонд цахим гарал үүслийн гэрчилгээ олгосон.<br>- Хүлэмжийн аж ахуй эрхэлж буй 110 иргэн, аж ахуйн нэгжийн тариалалт, хүлэмжийн ашиглалт, тариалалт, ургац хураалтын байдалд хяналт тавин, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | | |
| 5. | Арга хэмжээ 1.5.<br>Малд үзлэг ангилалт хийх, ялган тэмдэглэл тэмдэглэж бүртгэлжүүлэх, удам зүйн үнэлгээ хийх замаар малын ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлох, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан ажлын тоо | - | - | "Глобал Сивик Шэйринг" ТББ-тай хамтран эрчимжсэн мал аж ахуй, эрхлэгчдийг дэмжиж малын үүлдвэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх "Хүртээмжтэй мал аж ахуй" төслийн хүрээнд "Мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах" 5 өдрийн вакуумжуулсан сургалтыг зохион байгуулж, 15 фермер эрхлэгчийг хамруулсан.<br>Сүүний үхрийн үүлдэрлэг байдлыг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, үржлийн бух, гойд ашиг шимт үнээнд үзлэг, ангилалт, баталгаажуулалт, ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн ажлын хүрээнд үржлийн бух, саалийн үнээтэй айл өрхийн судалгааг нарийвчлан гарган мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна. | 2024.01.02-2024.12.31 | 100% |
| **Зорилт 2. Хүнсний аюулгүй байдлыг хангах, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.<br>Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулж ажиллана. | Худалдаа зохион байгуулсан байршлын тоо, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ | 5 удаагийн арга хэмжээнд 40.9 гаруй тонн төмс, хүнсний ногоог худалдаж, 120.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. | - | Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа болон жижиглэн худалдааг давхардсан тоогоор 5 байршилд зохион байгуулж, нийт 30 газар тариалан эрхлэгчийн 97.2тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулж, 143.3сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан ажилласан. | 2024.08.07-2024.11.01 | 100% |
| 2. | Арга хэмжээ 2.2.<br>Эрсдэл үүссэн үед малчин, мал бүхий иргэдийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах | Малчин, мал бүхий иргэдэд өвс, тэжээлийн | 40тн-оос багагүй хэмжээний өвс, тэжээлийн дэмжлэг үзүүлсэн байна. | Бэлтгэсэн өвс, тэжээлийг шаардлагатай | Нийслэлийн хэмжээнд мал аж ахуйн салбарт өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан Засаг даргын нөөц хөрөнгөөс мал бүхий 12,13,14 дүгээр хорооны давхардсан тоогоор 1460 өрхөд 237.тн өвс, | 2024.01.02-2024.04.07 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулж, дүүргийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна. | дэмжлэг үзүүлсэн тоо хэмжээ | | цэгүүдэд байршуулж, малчдад тараасан байна. | 66.9тн хивэг, 65тн улаан буудайн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | | |
| 3. | Арга хэмжээ 2.3<br>Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувь | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 9 удаагийн дархлаажуулалтад 340708 мал, амьтан хамрагдаж, 97.2 хувь, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 удаагийн дархлаажуулалтад 105425 бог мал, гүйцэтгэл 98.9 хувь | 90% | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:<br>- Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулах мал эмнэлгийн нэгжтэй мал эмнэлгийн нэгжүүдтэй ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх гурвалсан гэрээг шинэчлэн байгуулж гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.<br>- 2024 оны байдлаар Мал эмнэлгийн ажил үйлчилгээнд 6 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, Засаг даргын нөөцөөс 29.2 сая төгрөгийг үйл ажиллагааны зардлыг олгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан.<br>- Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан буюу https://livestock.mofa.gov.mn/ цахим системд 2023 оны мал, тэжээвэр амьтны тооллогоор тоологдсон 781 өрхийн 46919 мал, 2024 оны мал төллөлтөөр төллөсөн 631 төл буюу 10 унага, 434 тугал, 121 хурга, 66 ишиг, 2050 том мал хорогдсоноос 247 адуу, 250 үхэр, 713 хонь, 845 ямаа тус тус бүртгэн мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулсан.<br>- Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 4 удаагийн дархлаажуулалтад 136070 мал, амьтан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 7 удаагийн дархлаажуулалтад 227951 мал, амьтныг тус тус хамруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | 2024.01.02-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Дүүргийн Засаг даргын 2024 оны А/125, А/225 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулж, 3389 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 12000м2 талбай, 11000м2 талбай бүхий хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлтийг дүүргийн мал эмнэлгийн тасаг, Тохижилт үйлчилгээний төвтэй хамтран зохион байгуулж ажилласан. | | |
| 4. | Арга хэмжээ 2.4. Болзошгүй гамшиг ослын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулсан ажлын тоо | Болзошгүй гамшиг ослын үед хүнс нийлүүлэх гэрээг 30 аж ахуйн нэгжтэй байгуулж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгаа, хүн хүч, агуулах, хүнс тээвэрлэх тээврийн хэрэгслийн судалгааг нарийвчлан гаргаж, бэлэн байдлыг хангуулан ажилласан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд:<br>- Болзошгүй гамшиг ослын үед хүнс нийлүүлэх гэрээг хүнс, худалдаа, хоол үйлдвэрлэл, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 32 аж ахуйн нэгжтэй байгуулж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгаа, хүн хүч, хүнс тээвэрлэх тээврийн хэрэгслийн судалгааг нарийвчлан гаргасан.<br>- Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны үлгэрчилсэн загварын дагуу 5 бүлэг бүхий "Хан-Уул дүүргийн гамшгаас хамгаалах Хүнсээр хангах албаны төлөвлөгөө"-г шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>- Үер усны аюулын байдал үүссэн 3 удаагийн арга хэмжээнд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүн, штабын бүрэлдэхүүн, эрсдэлтэй бүсээс нүүн шилжин ирсэн болон түр хорогдох байранд байршуулсан иргэдэд эрүүл ахуйн шаардлага хангасан, халуун хоол цайгаар хангаж, хүнсний аюулгүй байдалд хяналт тавин ажилласан. | 2024.01.02-2024.12.31 | 100% |
| **Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. Цахим болон цаасан баримт бичгийг хүлээн | Албан бичгийн тоо, | Дээд газар болон бусад байгууллагаас | 100% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн erp.ulaanbaatar.mn системийн үйл ажиллагаар албан | 2024.01.02-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авах, хуулийн хугацаанд шийдвэрлэх, албан хэрэг хөтлөлтийн талаарх бодлого стандарт журмыг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах. | шийдвэрлэлтийн хувь | ирүүлсэн 145 албан бичгийг хүлээн авч 100% шийдвэрлэж, холбогдох хэлтэс албадад 87 албан бичиг боловсруулан хүргүүлсэн. | | хэрэгцээндээ хэрэгжүүлж, 2024 оны байдлаар:<br>- Дээд газар болон бусад байгууллагаас ирүүлсэн 183 албан бичгийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн.<br>- Дээд газар болон холбогдох хэлтэс албадад 106 албан бичиг боловсруулан хүргүүлсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 3.2.<br>Иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг судлан, хуулийн дагуу шийдвэрлэн хариу өгөх. | Өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Иргэдээс ирсэн 21 өргөдлийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн. | 100% | Иргэд, байгууллагаас ирсэн 38 өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг судлан, хуулийн дагуу шийдвэрлэн хариу өгсөн. | 2024.01.02-2024.12.31 | 100% |
| 3. | Арга хэмжээ 3.3.<br>Баримт бичгийг албан бичгийн стандартын дагуу зохион бүрдүүлэх, архивын стандартад нийцүүлэн байгууллагын архивт хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгөх. | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээлгэн өгсөн баримтын тоо | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан 3 хадгаламжийн нэгжийг архивын стандартын дагуу үүсгэж, хуваарийн дагуу байгууллагын архивт хүлээлгэн өгсөн. | 2-оос доошгүй хадгаламжийн нэгж үүсгэн, архивчид хүлээлгэн өгсөн байна. | 2023 оны батлагдсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан 2 хадгаламжийн нэгжийг архивын стандартын дагуу үүсгэж, хуваарийн дагуу байгууллагын архивд хүлээлгэн өгсөн. | 2024.02.01-2024.03.25 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>Зөвшөөрөлгүй байршуулсан түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулах. | Нүүлгэн шилжүүлсэн түргэн үйлчилгээний цэгийн тоо | 94 түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлсөн. | Иргэдийн өргөдөл гомдлын дагуу нийтийн эзэмшлийн зам талбайд | Дүүргийн Засаг даргын 2024 оны "Газрын зөрчил арилгаж, албадан чөлөөлөх арга хэмжээ авах тухай" А/27 дугаар захирамжийн хэрэгжилтийг хэрэгжилтийг хангах хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй байршуулсан, зорчих хэсгийг хаасан, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, орчны бохирдол ихээр үүсгэж буй 29 түргэн | 2024.03.19-2024.05.01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зөвшөөрөлгүй байршуулсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний зорчих хэсгийг хаасан, эрүүл ахуйн шаардлага хангахгүй түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэн шилжүүлсэн байна. | үйлчилгээний цэгийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулсан. | | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/35 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан тухай. | Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | - | Илэрсэн зөрчил, дутагдлыг 80-с дээш хувьтай арилгуулна. | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/35 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт алжаал тайлах төвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 34 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулж, хугацаатай үүрэг даалгавар өгч, зөрчлийг арилгуулан ажилласан. | 2024.03.27-2024.04.18 | 100% |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Хан-Уул дүүрэгт хийгдэж буй бүтээн байгуулалт, | Зохион байгуулсан уулзалтын тоо | - | Худалдаа, хоол үйлдвэрлэл | Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, хүнсний болон хөнгөн үйлдвэрлэл, үл хөдлөх жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнес | 2024.03.15-2024.05.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгө оруулалтын ажлын явц, үр дүнг танилцуулан, орон нутгийн хөгжилд бизнесийн байгууллагуудын санаачилга, идэвх оролцоог нэмэгдүүлэх санал солилцох уулзалтыг аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулсан тухай. | | | үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 300 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан байна. | эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хууль тогтоомжийг сурталчлах, дүүргийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг танилцуулах, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, уулзалт хэлэлцүүлгийг нийт 12 удаа зохион байгуулж, 912 гаруй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. | | |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.<br>Нөөцийн махны өргөтгөсөн худалдаанд хяналт тавьж ажилласан тухай. | Өргөтгөсөн худалдаа зохион байгуулсан тоо, борлуулсан махны хэмжээ | Нөөцийн махны худалдааг хүнсний дэлгүүр, сүлжээ 33 дэлгүүрээр 52.9тонн мах, 14 өргөтгөсөн худалдаагаар 141.9 тонн нийт 194.8 тонн махыг худалдаалах ажлыг зохион байгуулсан. | 100 тонноос багагүй нөөцийн мах борлуулагсан байна. | Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2024 оны А/233 дугаар тушаалын хүрээнд нөөцийн махны худалдааг хүнсний дэлгүүр болон сүлжээ 41 дэлгүүрээр худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан. Үүнд:<br>- Жижиглэнгээр 37.2 тонн,<br>- 28 удаагийн өргөтгөсөн худалдаагаар 172.1 тонн, нийт 209.3 тонн мах худалдаалж, махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийн гомдол санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн ажилласан. | 2024.04.15-2024.05.31 | 100% |
| 5. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.<br>Авто үйлчилгээ эрхлэгчдэд хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулан, хяналт шалгалт зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | Хотын стандарт, хяналтын газрын улсын ахлах байцаагчийн "Автомашин угаалгын үйлчилгээнд тавигдах шаардлага, аюулгүй байдал, үйлчилгээний эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах тухай" 04-13-01/036/12 дугаар зөвлөмжийг 30 газарт хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.<br>Нийслэлийн Нийтийн тээврийн газар, Хотын стандарт хяналтын газартай хамтран "Авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох журам"-ын хэрэгжилтийг хангуулах | 2024.02.01-2024.06.01 | 100% |

1208

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулж, 119 газрын судалгааг хүргүүлсэн. | | |
| 6. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн нэгдсэн арга хэмжээнд худалдаа, үйлчилгээ зохион байгуулж, хналт тавих тухай. | Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | 10 | Эрүүл ахуйн шаадлага хангасан худалдаа, үйлчилгээ гаргасан байна. | "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн нэгдсэн арга хэмжээг "Степпе арена" спорт цогцолбор болон "Төв цэнгэлдэх хүрээлэн"-д зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 26 иргэний бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан борлуулалтыг дэмжин, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаанд хяналт тавин ажилласан. | 2024.05.31-2024.06.01 | 100% |
| 7 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. Үндэсний их баяр наадмаар Төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаа үйлчилгээ зохион байгуулж, хяналт тавьж ажиллах. | Худалдаа, үйлчилгээ гаргасан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | Нийт 177 хүсэлтээс тавигдах шаардлагын дагуу шаардлага хангаж буй хоол үйлдвэрлэлийн 39 аж ахуйн нэгж, хүнсний худалдаа 22 иргэн, аж ахуйн нэгж, хүнсний бус худалдаа 15 иргэн нийт 76 хүсэлтийг баталгаажуулан шийдвэрлэсэн. | 50-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан байна. | Үндэсний их баяр наадмаар Төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаа үйлчилгээ эрхлэх хоол үйлдвэрлэл үйлчилгээний 48, хүнсний худалдааны 8 нийт 56 иргэн аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгож, хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулан ажилласан. | 2024.07.08-2024.07.13 | 100% |
| 8 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. Дүүргийн менежерийн 2024 оны "Хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх" удирдамжийн хүрээнд хоол үйлдвэрлэлийн газруудаар хамтарсан хяналт | Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо | - | 10 хүртэлх ахуйн нэгж хамрагдсан байна. | Дүүргийн менежерийн баталсан удирдамжийн дагуу холбогдох байгууллагуудтай хамтран 4,5,8,23,24, дүгээр хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэлийн газрууд хяналт шалгалтыг зохион байгуулж, 13 аж ахуйн нэгж хамрагдаж, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 2 газрын архи, согтууруулах ундааг хураан авч, зөрчлийн тухай хуулийн дагуу цагдаагийн байгууллагаас 5.5 сая төгрөгийн | 2024.11.04 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгалтын ажлыг зохион байгуулна. | | | | торгуулийн арга хэмжээ авсан зөрчил дутагдлыг арилгуулан ажилласан. | | |
| 9 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9. Дүүргийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй ил задгай худалдаа эрхлэгчдэд хяналт тавьж ажиллах тухай. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | Дүүргийн менежерийн 2024 оны "Ил задгай худалдаа эрхлэгчдэд хяналт шалгалт хийх тухай" удирдамж, хуваарийн дагуу холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалт хийж, Цагдаагийн газраас давхардсан тоогоор 45 иргэнд 900 нэгжийн торгуулийн арга хэмжээ авч, зөвшөөрөлгүй худалдаа үйлчилгээг тухай бүр зогсоон ажилласан. | 2024.10.30 2024.12.31 | 100% |
| 10 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд цас мөсний цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж ажиллах. | Хяналт тавьж ажилласан тоо | Давхардсан тоогоор 2852 иргэн, аж ахуйн нэгжид хариуцах орчны 50 метр хүртэлх цас мөсний цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж, цэвэрлэгээний багаж хэрэглэлийн бэлэн байдлыг хангуулан ажилласан. | 3-4 удаагийн хяналт тавьж ажиллана. | Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй давхардсан тоогоор 955 иргэн, аж ахуйн нэгж хариуцах орчны 50 метр хүртэлх нийт 26123м2 бүхий нийтийн эзэмшлийн зам талбайн цас мөсийг цэвэрлэж, цэвэрлэгээний багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллах, халтиргаа гулгаанаас хамгаалсан шалавч резин хийх, цэвэрлэгээг чанаржуулах талаар үүрэг чиглэл өгч, хяналт тавин ажилласан. | 2024.11.26 2024.12.31 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо хэмжээ | Дээд шатны болон Тамгын газраас зохион байгуулсан 8 удаагийн сургалт, семинарт хамрагдсан | 4 | Дээд шатны болон Тамгын газраас зохион байгуулсан цахим болон танхимын 9 удаагийн сургалт, семинарт хамрагдсан. Үүнд:<br>1. "Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-гийн тухай сургалт | 2024.03.20-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх”<br>3. “Төрийн албан хаагчдад цахим мэдлэг чадвар олгох сургалт”<br>4. Стресс менежмент<br>5. “Мал эмнэлгийн нэгдсэн систем 2.0, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан ба тэдгээрийн уялдаа холбоо”<br>6. Монгол бичгийн цахим бичвэрийн сургалт<br>7. Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй<br>8. Сүүний урамшууллын талаарх цахим сургалт<br>9. Идэвхтэй хөдөлгөөн эрүүл мэнд сургалт | | |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн хэрэглээний болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмшинэ. | Суралцсан сургалтын тоо | Зохиолч, Ментор Т.Гүлдаурений хувь хүний хөгжлийн хөтөлбөрүүд болох “Mommy mentor” 15 өдрийн цахим хөтөлбөрт хамрагдсан. | - | “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний багийн гишүүн бэлтгэх 100% цахим богино хугацааны сургалтад хамрагдсан. | 2024.05.31-2024.06.03 | 90% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

............................ /Б.НАРАНТУЯА/

2024.12.02

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХАРИУЦСАН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН БЯМБАДОРЖИЙН НАРАНТУЯАГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр:Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах, хяналт тавих хүрээнд** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 1.2. | 50 | 10 | 60 | |
| 3. | Арга хэмжээ 1.3. | 60 | 5 | 65 | |
| 4. | Арга хэмжээ 1.4. | 60 | 10 | 70 | |
| 5. | Арга хэмжээ 1.5. | 50 | 5 | 55 | |
| **Зорилт 2. Хүнсний аюулгүй байдлыг хангах, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах хүрээнд** | | | | | |
| 6. | Арга хэмжээ 2.1. | 60 | 10 | 70 | |
| 7. | Арга хэмжээ 2.2. | 60 | 10 | 70 | |
| 8. | Арга хэмжээ 2.3. | 60 | 10 | 70 | |
| 9. | Арга хэмжээ 2.4. | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд** | | | | | |
| 10. | Арга хэмжээ 3.1. | 60 | 10 | 70 | |
| 11. | Арга хэмжээ 3.2. | 60 | 10 | 70 | |
| 12. | Арга хэмжээ 3.3. | 60 | 10 | 70 | |
| **Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт** | | | | | |
| 13. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.** | 60 | 10 | 70 | |
| 14. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.** | 60 | 10 | 70 | |
| 15. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.** | 60 | 10 | 70 | |
| 16. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.** | 60 | 10 | 70 | |
| 17. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.** | 60 | 10 | 70 | |
| 18. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6.** | 60 | 10 | 70 | |
| 19. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7.** | 60 | 10 | 70 | |
| 20. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8.** | 60 | 10 | 70 | |
| 21. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9.** | 60 | 10 | 70 | |
| 22. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10.** | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | 68.6 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1. | | 15 | |
| 2. | Арга хэмжээ 2. | | 10 | |
| | **Дундаж оноо** | | 12.5 | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| | **Дундаж оноо** | 7 | |

## 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 7.8 |
| | **Дундаж оноо** | 7.9 |

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 68.6 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 12.5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(7 хүртэлх оноо)* 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 7.9 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| | **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | 96 |

***Үнэлгээ өгсөн:***
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

***Нэгжийн дарга***
.............................. /Л.Саруултуяа/

(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

..........2024.12.13 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Хүнс, хөдөө аж ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн ................................ /Б.Нарантуяа/
..2024.12.13.. (огноо)

***Үнэлгээг хянасан:***
*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга ................................ /Л.Отгонбаяр /
..2024.12.13.. (огноо)

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*
Хүний нөөц, ёс зүй хариуцсан мэргэжилтэн ................................ /Б.Саранцацрал/
..2024.12.13.. (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ /З.Буянт/
..2024.12.13(огноо)